

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2010 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЙЛАН**

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 79 дүгээр тогтоолоор баталсан Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудаас аймгийн Засаг даргын бүрэн эрхэд хамаарах болон тус аймгийн нэр зааж орсон 46 зорилтыг хяналтанд авч, хэрэгжилтийг зохион байгуулж ирсэн.

Эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтууд нь тухайн ондоо бүрэн хэрэгжиж дуусах зорилтууд байх учиртай гэж үзэж, 100,0 хувийн гүйцэтгэлтэй байх гэсэн шалгуурыг баримталсан болно.

Ийнхүү өгсөн үнэлгээгээр:

Хяналтанд авсан нийт зорилтын тоо	Хэрэгжилтийн явцын үнэлгээ							Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	Дундаж хувь
	0,0	10,0	30,0	50,0	70,0	90,0	100,0		
46				3	4	16	18	5	89,5

Дундаж хувь 89,5, үнэлгээний оноо 4,47 байна.

Хэдийгээр Дорноговь аймагт хэрэгжих боловч орон нутгийн төр, захиргааны байгууллагын шууд удирдлага, зохицуулалтаар хэрэгжихгүй, Засгийн газар, салбарын яам, агентлаг хариуцах 5 асуудлын биелэлтийг “орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй” гэсэн тайлбар хийж, үнэлгээ тавиагүй болно.

/Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудын хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав/

* * *

ДОРНОГОВЬ АЙМАГ

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ 2010 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

/ Монгол Улсын Их Хурлын 2009 оны 79 дүгээр тогтоолоор баталсан/

2010 оны жилийн эцсийн байдлаар:

№	Зорилтын дугаар, хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлтийн тухай тэмдэглэл	Хувь
1	1.2. Цагаан суврагын зэсийн ордод түшиглэн уул уурхайн иж бүрэн цогцолбор байгуулах, эрчим хүчээр хангах техник, эдийн засгийн үнлэслэл боловсруулж, гэрээ хэлэлцээ хийж, ажлыг эхлүүлэх	“Өмнөд говийн бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 151 дүгээр тогтоолд Цагаан суврагын зэс, молибдений орд болон түүний ойр орших бусад ордуудыг түшиглэж уул уурхайн баяжуулах үйлдвэр барих ажлыг 2010-2015 онд хэрэгжүүлэхээр тусгасан. Цагаан суврагын зэсийн ордод хайгуулын лиценз эзэмшдэг “Монголын алт” ХХК Цагаан суврагаас Зүүнбаян хүртэл хатуу хучилттай зам барьж, ашигт малтмалын тэвэрлэлт хийх хүсэлтээ илэрхийлсний дагуу аймгийн Засаг даргын 2010 оны а/434 дүгээр захирамжаар 154,3 км авто замын трасыг баталсан. 2011 онд уг замыг барьж, 2012 оноос үйлдвэрийг ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй байгаагаа “Монголын алт” ХХК мэдэгдээд байгаа.	50
2	1.5. Таван толгой-Цагаан суврага-Сайншандын төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах	Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Өмнөд говийн бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр”-т Таван толгой-Цагаан суврага-Сайншанд чиглэлийн төмөр замын суурь бүтцийг 2010-2015 онд байгуулахаар тусгасан. Төмөр зам байгуулахад оролцох саналаа илэрхийлсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид олноор ирж, танилцах, судлах ажилд оролцож байна. Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын урилгаар 2009 оны 10 дугаар сард Солонгос улсын Төмөр замын сүлжээний Хэрэг эрхлэх газрын дарга Чо Хюён Ёнг тэргүүтэй төлөөлөгчид тус аймагт ажлын айлчлал хийж Зүүнбаян-Оюу толгойн төмөр замыг тавих асуудлаар судалгааны ажлыг эхлүүллээ. Энэ багт Daewoo, lotte, Hyundai зэрэг Солонгосын томоохон компаниудын төлөөлөгчид ирж оролцлоо. Мөн ЗТБХБЯ, Төмөр замын газрын хариуцлагатай ажилтнууд ирж ажиллав. Монгол улсын төмөр замын сүлжээг өргөтгөхөд хамтран ажиллах санамж бичигт Оросын Холбооны улсын „Оросын төмөр зам,, ХК-ын ерөнхийлөгч Якунин, ЗТБХБ-ын сайд Х.Баттулга нар Улаанбаатар хотод гарын үсэг зурсан байна.	70
3	6.5. Сум бүрт 5 /баг бүрт 1/-аас доошгүй худаг гаргах	2010 онд улсын төсвийн 148,5 сая төгрөгийн хөрөнгөөр 7 худаг гаргаж, 30 худагт их засвар хийлээ. Мөн Япон улсын “Өвсний үндэс” төслийн хөрөнгөөр 3 худаг шинээр гаргаж, 6 худагт их засвар хийсэн. Энэ ажлыг Улаанбаатар хотын “Цахиурт баян” ХХК гүйцэтгэсэн байна. Улсын төсвийн 160,0 сая төгрөгийн хөрөнгөөр усны хайгуулын ажлыг 5 сумын 80 цэгт Улаанбаатар хотын “Нэмэр интернэшл” ХХК гүйцэтгэсэн. “Тогтвортой амьжиргаа-2” төслөөр энгийн уурхайн 64 худгийг шинээр гаргасан буюу засварласан. Дээрхи арга хэмжээнүүдийн үр дүнд бэлчээрийн нийт талбайн 41,9 хувь нь усжуулагдаж, усжуулсан талбайн хэмжээ өмнөх оныхоос 1,9 хувиар нэмэгдсэн байна.	100

		Малчид хүч хөдөлмөрөө хорших замаар 58 худаг шинээр гаргасан нь багт дунджаар 1 худаг оногдож байгаа юм.	
4	6.19. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжсэн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, түүний зарим хэсгийг зээлийн баталгааны сан, тоног төхөөрөмжийн лизинг, хүүгийн хөнгөлөлт бий болгоход зарцуулах	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар 2010 онд 656,0 сая төгрөгийн зээл олгосон. Үүний үр дүнд 162 ажлын байр шинээр нээгджээ. Зээл авсан аж ахуйн нэгжүүдээс “Мөнх тэнгэрийн увидас” ХХК тоосгоны үйлдвэр байгуулж, 200 сая төгрөгийн тоног төхөөрөмж авч суурилуулаад байна. ХХААХҮЯ-ны дэргэдэх Жижиг, дунд үйлдвэрийн газраас “Тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээний журам”-ыг боловсруулсан бөгөөд 2011 оноос аймаг бүрийг 500,0 саяас доошгүй төгрөгийн лизингийн эх үүсвэртэй болгох юм. Одоогийн байдлаар ХХААХҮЯ-наас газар тариалангийн иж бүрдэл бүхий дунд оврын трактор, дуслын усалгааны системтэй хүлэмж нийлүүлж эхлээд байгаагаас тус аймагт 2 трактор, 2 хүлэмж нийлүүлэгдээд байна. Сумдад жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зориулалттай “Сум хөгжлийн сан” байгуулсан. Аймгийн “Шинэ Дорноговь” хөгжлийн сангаас „Сум хөгжлийн сан,-гуудад нийтдээ 70.0 сая төгрөгийн хөрөнгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 171,5 сая төгрөгийн зээлийг 156 иргэнд, иргэдийн үүсгэл санаачлагын оролцоонд түшиглэсэн 27 бүлгийн 180 иргэнд 18,0 сая төгрөгийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн сангаас олгосон	100
5	6.20. Хөдөөгийн иргэд бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнээ борлуулах биржийн сүлжээ байгуулах бэлтгэлийг хангах	Хөдөө аж ахуй, үүний дотор мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах жижиг үйлдвэрлэл, бараа, түүхий эдийн бирж байгуулах ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж ажиллах үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын 2010 оны а/173 дугаар захирамжаар байгуулж ажиллуулж байна. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн борлуулах зах байгуулах газрын дуудлага худалдааг Сайншанд суманд 2010 онд зохион байгуулсан. ДЕВКО ХХК уг газрыг 96,5 сая төгрөгөөр худалдан авч, зах байгуулах ажилдаа ороод байна. Сумдад сүү, цагаан идээ болон төмс, хүнсний ногоо худалдах төвлөрсөн цэг байгуулах, мал нядалгааны газар байгуулах, арьс шир, ноос ноолуурын биржийн худалдаа эрхлэх санал бүхий 12 иргэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас нийтдээ 141,4 сая төгрөгийн зээл авч, үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.	70
6	6.28. Сорилын лабораториудыг хүнсний болон бусад бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлэх	УБТЗ-ын Эрчим хүч ус хангамжийн 2 дугаар ангийн усны тоолуурын тохируулгын лабораторийг аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс /цаашид СХЗХ гэх/ гэрээгээр ашигладаг. Хүнсний бүтээгдэхүүний хүнд элемент, хорыг тодорхойлох нэгдсэн лаборатори байгуулах зорилгоор “Нэгдсэн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх” төслийг СХЗХ боловсруулж холбогдох газруудад хүргүүлээд байна. Мөн тус хэлтэс аймгийн Эрүүл мэндийн газартай хамтарч “Эрүүл ахуйн лабораторийг бэхжүүлэх” төсөл боловсруулж Азийн хөгжлийн сорилтын сангийн төслийн нэгжид хүргүүлсэн байна. Аймгийн СХЗХ хэмжүүр, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг график, төлөвлөгөөний дагуу сумдад жилд 2-оос доошгүй удаа явж хийж байна. СХЗХ-ийн дэргэдэх лаборатори нэг цэгийн зарчмаар ажиллаж, физик, хими, хор судлал, нян судлалын үйлчилгээ үзүүлж, иргэдэд чирэгдэлгүй үйлчилж байна. Мөн халуун, хүйтэн усны тоолуурын итгэмжлэгдсэн лабораторитой болсон.	90
7	6.33. Мал аж ахуй, газар тариалангийн эрчимжсэн	Хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдэд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих	

	фермерийн аж ахуйг хөгжүүлэх малчид, тариаланчдын бүлэг, хоршоо байгуулах санаачилгыг дэмжих	сангаас 2009 онд 156.7 сая, 2010 онд 240.7 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгосон. Зээлийн хөрөнгийн 70 гаруй хувь нь сүүний фермерийн аж ахуй байгуулах, өргөтгөхөд чиглэгдэж, одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 168 үнээ бүхий фермерийн хэлбэрийн 7 аж ахуй үүсэн байгуулагдаад байна. Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбооны салбар зөвлөл тус аймагт 23 гишүүнтэйгээр байгуулагдлаа. Аймгийн хэмжээнд цэвэр, эрлийз, омгийн мал 2010 онд 359,9 мянган толгой болж өмнөх оныхоос 22.0 хувиар өсчээ. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн аймгийн зөвлөгөөнийг 2009, 2010 онуудад зохион байгуулж, мал аж ахуй, үүний дотор эрчимжсэн аж ахуйн талаар баримтлах төр засгийн болон орон нутгийн бодлогыг танилцуулж, оролцогчдын санал хүсэлтийг сонсч, цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ирсэн юм. Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжсэн бодлогын үр дүнд нилээд ахиц гарлаа. 2009 онд 183.7 тн төмс, 144.7 тн хүнсний ногоо хураан авч байсан бол 2010 онд 208,3 тн төмс, 277,5 тн хүнсний ногоо хураан авсан байна. 2010 онд хураан авсан төмс өмнөх оныхоос 11,3 хувь, хүнсний ногоо 91,4 хувиар тус тус нэмэгдэж, төмс, хүнсний ногооны жилийн хэрэгцээний 22,0 хувийг аймгийн дотоодын ургацаас хангах боломж бүрдлээ.	100
8	7.2. Дорноговийн сав газрын БХГ-97 талбайн Зүүнбаян, Цагаан элсний ордод хайгуулын үйл ажиллагаа дуусч байгаатай холбогдуулан үйлдвэрлэлийн олборлолтонд шилжүүлэх ажлыг эхлүүлэх	Хэрэгжилтийн үнэлгээг орон нутгаас гаргах боломжгүй	-
9	8.12. Замын-Үүд өртөөний нарийн царигийн төмөр замыг хагас автомат хориглолд шилжүүлэх, ачааны терминалын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	Хэрэгжилтийн үнэлгээг орон нутгаас гаргах боломжгүй	-
10	8.16. Ачаа тээврийн ложистик төвийг Замын-Үүдэд барих бэлтгэл ажлыг хангах	Замын-Үүд сумын төвд барих улс, хот хоорондын авто вокзалын барилгын зураг төслийг боловсруулсан, 2,6 га газар олгосон, одоогийн байдлаар орчны хашаагаа бариад байна. “Концессын зүйлийн жагсаалт батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 2010 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 198 дугаар тогтоолоор Замын-Үүд суманд хот хоорондын зорчигч, ачаа тээврийн авто вокзал барих асуудлыг концессын зарчмаар шийдвэрлэхээр тогтоосон байна.	50
11	8.22. Чойр-Замын-Үүдийн авто замын А багцын 176,4 км замыг үргэлжлүүлэх, Б багцын 131,3 км, NP-1 багцын 62,2 км, Өргөн сум хүрэх 18,2 км замуудыг ашиглалтанд өгөх, Замын-Үүд чиглэлийн 61,8 км замын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, барилгын ажлыг эхлүүлэх	Төмөр замын 35 дугаар зөрлөгөөс 18-ын худаг хүртэлх 135,8 км замыг China Geo Engineering Corporation компани, 18-ын худгаас урагш 62 км замыг Shengli компани, гүйцэтгэж байгаа юм. Төмөр замын 35 дугаар зөрлөгөөс Хангинуурын даваа хүртэлх авто замыг 2010 онд багтаан хучих зорилт тавиад ажиллаж байна. Замын-Үүдээс наашхи 62 км замыг Азийн хөгжлийн банкны 16.0 сая ам.долларын буцалтгүй тусламж, 8.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх болж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан, одоогоор тендерийн үнэлгээ хийгдэж байна. Чойр-Сайншандын 176.4 км автозамыг Мянганы сорилтын сангийн 43.8 сая ам.долларын	70

		хөрөнгөөр барихаар шийдвэрлэсэн. 2010 оны 9 дүгээр сард хийсэн замын ажлын шав тавих ёслолд Монгол улсын Ерөнхий сайд оролцов. Уг замыг БНСУ-ын “Эл Ай Жи” компани барьж, 2013 оны 4 дүгээр сард ашиглалтанд хүлээлгэж өгөхөөр гэрээ байгуулсан байна. ЗТБХБЯ, Монголын Мянганы сорилтын сангийн Авто замын төслийн хооронд харилцан ойлголцлын санамж бичиг үйлдэж, ЗТБХБ-ын сайд Х.Баттулга, ММССангийн гүйцэтгэх захирал С.Баярбаатар нар 2010 оны 10 дугаар сард гарын үсэг зурлаа. Санамж бичигт гарын үсэг зурснаар замын ажлын явцад тавих төрийн хяналт сайжрах юм.	
12	8.25. Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүдийн хурдны авто замын техник, эдийн засгийн үнлэслэл боловсруулж, хөрөнгө оруулагчидтай гэрээ, хэлэлцээрийг эхлүүлэх	Хэрэгжилтийн үнэлгээг орон нутгаас гаргах боломжгүй	-
13	8.27. Бүх аймгийн төвд 5-10 км урттай хатуу хучилттай авто зам шинээр тавих	2010 онд Сайншанд сумын Ноён хутагтын гудамж, Энх тайвны гудамжны 4,45 км авто замын зургийг “ХЗТ автозам” ХХК-аар 9,4 сая төгрөгийн хөрөнгөөр, уг замын засварын ажлыг “Замын битум” ХХК улсын төсвийн 739,9 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус гүйцэтгэсэн.	100
14	8.34. Бүх аймаг, сумын төвүүдэд ахуйн үйлчилгээний төв байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх, олон улсын зээл, тусламж, хөтөлбөр, төсөлд хамруулах	Алтанширээ сумын ЗДТГ „Модон шанд,, ХХК-тай гэрээ байгуулж хуучин барилгыг засварлан, ахуйн зарим үйлчилгээг иргэддээ үзүүлдэг болсон, Дэлгэрэх сумын „Залуу хүч,, ХХК нийтийн аж ахуйн зарим тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг төслийн хөрөнгөөр бэлтгэж, байр гарган үйлчилгээ явуулах сонирхолтой иргэдэд түрээсээр эзэмшүүлээд байна. Мандах суманд “Тогтвортой амьжиргаа” төслийн 28.1 сая төгрөгийн хөрөнгөөр ашиглалтгүй байсан барилгын их засвар хийж, нийтийн ахуйн үйлчилгээний цэгийг 2010 онд байгууллаа.	90
15	10.3. Хот суурин газарт цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж байгуулах ажлыг өргөжүүлэх	2010 он Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар мод тарих үндэсний өдөртэй болсон, “Ойн менежментийг боловсронгуй болгох жил” болгон зарласан, “Монголоо ногоорууль” аян зохион байгуулсан онцлогтой жил байлаа. Дээрхи бодлогын шийдвэр, зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд 44.3 мянган мод, бут, сөөгийг 30.9 га талбайд тариалж, энэ арга хэмжээнд сум, аймгийн орон нутгийн төсвөөс 21.1 сая, иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хандивлагчдын 9.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.	100
16	11.8. Цөлжилтөөс сэргийлэх, хөрс хамгаалах ажлыг эрчимжүүлэх, сургалт зохион байгуулах	Сайншанд сумын ЗДТГазар „Ногоон Сайншанд,, хөтөлбөр боловсруулж сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 8/01 дүгээр тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний алхам болгож 2010 онд Сайншанд сумын баруун хэсэгт 15 га ойн зурвас шинээр байгуулж, 5000 мод суулгалаа. Энэ ажлыг “Монгол тарвас” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн ба “Шинэ Дорноговь” хөгжлийн сангаас 13,4 сая, БОАЖ-ын сайдын багцаас 7.3 сая, орон нутгийн төсвөөс 3,5 сая төгрөгийн хөрөнгө тус тус шийдвэрлэсэн болно. Замын-Үүд суманд хэрэгжсэн, цөлжилттэй тэмцэх урт хугацааны төслүүдийн хөрөнгөөр 240 га талбай бүхий ойн зурвас байгуулан, 66 мянган мод, бут тарьж ургуулсан юм. 2009 онд ойн зурвасын хэмжээг нэмэгдүүлж, шинээр 2 га талбайд ойн зурвас байгуулж, 1000	100

		<p>ш мод тарьсан байна. “Цөлжилттэй тэмцэх, газрын тогтвортой менежмент” төслийг Замын-Үүд суманд хэрэгжүүлэх саналыг төслийн ажлын албанд хүргүүлээд байна. Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нутагт шинээр цэцэрлэгт хүрээлэн байгуулж, хаврын тариалалт хийлээ. БНХАУ-ын Эрээн хотын Засгийн ордны буцалтгүй тусламжаар Замын Үүд суманд 740 гаруй суулгац бүхий „Найрамдал,, цэцэрлэгт хүрээлэн барьж ашиглалтанд оруулсан. Тус цэцэрлэгт хүрээлэнд явган хүний зам, хүүхдийн тоглоом, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж зэргийг байрлуулсан байна.</p> <p>БНСУлсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2.0 сая ам долларын өртөг бүхий „Дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, сэргээгдэх эрчим хүчний шинэчлэл хийх,, төсөл Мандах суманд хэрэгжиж, 120 кВт-ын нарны зайн цахилгаан үүсгүүр, одоо байгаа 80 кВт-ын салхин сэнс дээр 70 кВт-ын сэнс нэмж байрлуулах, акумляторын хүчин чадлыг нэмэх зэрэг асуудлыг шийдвэрлэх юм. Төслийн хүрээнд 2 цөөрөм тогтоох, хүлэмж байгуулах, гүний худаг гаргах зэрэг ажлуудыг хийж 2010 оны 9 дүгээр сард хүлээлгэн өглөө.</p>	
17	12.3. Аялал жуулчлалын статистик бүртгэл, мэдээллийн нэгдсэн сүлжээг сайжруулах	<p>“Дорноговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр” боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2010 оны а/147 дугаар захирамжаар байгуулсан. Уг ажлын хэсэг хөтөлбөрийг эцэслэн боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэхээр өргөн бариад байна. “Шинэ Дорноговь” хөгжлийн сангаас 5,0 сая төгрөгийн хөрөнгө гаргаж аймгийн аялал жуулчлалын газрын зургийг 2000 ширхэг хэвлүүллээ. Улсын төсвийн 68,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Хан хөхий” ХХК Хамарын хийдэд аялал жуулчлалын мэдээллийн төвийн барилга барьсан.</p>	90
18	13.2. АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжих “Говийн өмнөд бүсийн хот байгуулалт, хилийн боомтын хөгжлийн төсөл”-ийн хэлэлцээрийг байгуулах	<p>Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжих “Говийн зүүн өмнөд бүсийн хот суурин газар, хилийн хотуудыг хөгжүүлэх төсөл”-д тус аймаг хамрагдах болж, төслийн гэрээнд аймгийн Засаг дарга 2010 оны 6 дугаар сард гарын үсэг зурсан. Уг төслийн хөрөнгөөр Сайншанд сумын төвлөрсөн халаалтын 4 зуух, цэвэр усны 16.3 км, бохирын 23.1 км, дулааны 11.5 км шугам, цэвэрлэх байгууламжийг шинэчлэх бөгөөд холбогдох тооцоо судалгааг ЗТБХБЯ, ҮХШХ, Сангийн яаманд хүргүүлээд байна.</p>	50
19	13.9. Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу орон нутгийн түүхий эд, бусад нөөцөд тулгуурласан үйлдвэрлэлийг байгуулахад дэмжлэг үзүүлэх	<p>Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар олгох зээлийн санд төсөл сонгон шалгаруулах комиссыг аймгийн Засаг даргын 2010 оны а/406 дугаар захирамжаар, аймгийн Засаг дарга П.Ганхуягаар ахлуулан шинэчлэн байгуулсан. 2010 онд 46 төсөлд 653,0 сая төгрөгийн зээл олгож, зээлийн санг бүрэн зарцуулаад байна. “Дорноговь түншлэл”, “Намрын ногоон өдрүүд”, “Шилмэл мал” зэрэг үзэсгэлэн, худалдааг тус аймагт жил бүр зохион байгуулж, төвийн бүсийн хэмжээнд зохион байгуулагдсан арга хэмжээнд амжилттай оролцож ирлээ. Бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, оролцогчдын тоо жилээс жилд нэмэгдэж, сумдын нэрийн бүтээгдэхүүн олширч байна. Аж үйлдвэрийн салбарт 2420,1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2690,4 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, үйлдвэрлэлт өмнөх оныхоос 67,6 хувь, борлуулалт 35,7 хувиар нэмэгджээ. Аймгийн Засаг даргын 2010 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн а/131 дүгээр захирамжаар бизнесийн орчны шинэтгэлийн жилд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг зохион байгуулж ирлээ.</p> <p>Хөдөө аж ахуй, үүний дотор мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах жижиг</p>	90

		үйлдвэрлэл, бараа, түүхий эдийн бирж байгуулах ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж ажиллах үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын 2010 оны а/173 дугаар захирамжаар байгуулж ажиллуулж байна.	
20	15.2. Орон нутаг, томоохон хот суурин газруудын засаг, захиргааны байгууллагуудыг төрийн нэгдсэн мэдээллийн сан, сүлжээнд холбох	Дорноговь аймгийн болон Сайншанд сумын ЗДТГ вэб хуудастай бөгөөд түүнийг тогтмол шинэчилж, иргэд, хэрэглэгчдэд мэдээлэл түгээж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсрол, соёлын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Статистикийн хэлтэс, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар зэрэг аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний хэрэгжүүлэгч агентлагууд, Сайншанд, Замын-Үүд, Айраг, Даланжаргалан сумд харьяалах дээд байгууллагууд болон аймгийн ЗДТГ-тай сүлжээгээр харилцаж байгаа. Бүх сумдад төрийн сангийн нэгдсэн сүлжээ ажиллаж байгаа, энэ сүлжээгээр дамжуулж нэн яаралтай, шаардлагатай мэдээлэл солилцох боломжтой. Мөн түүнчлэн аймгийн Шүүх, Прокурор, Өмгөөлөл, Нотариат, Тагнуул зэрэг хууль, хяналтын байгууллагууд цахим сүлжээтэй болж, төвийнхөө байгууллагуудтай цахим хэлбэрээр мэдээлэл солилцож байгаа. Аймгийн Засаг даргын 2009 оны үйл ажиллагааны 13 багц тайланг Засгийн газрын ХЭГ-ын вэб сайтад оруулсан.	100
21	15.6. Шуудангийн салбаруудыг нэгдсэн сүлжээнд холбож, мэдээлэл, технологийн төв байгуулах	Аймгийн Засаг даргын 2010 оны а/166 дугаар захирамжаар орон нутагт нийтийн тээвэр, шуудан тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг аймгийн Шуудан үйлчилгээний газарт олгосон. Орон нутгийн зорчигч, тээврийн үйлчилгээнээс 2010 онд 813,5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Улаанбадрах сумаас бусад сумдад шуудан 7 хоногт 2 удаа явж байна. Харин хэвлэл захиалга бараг байхгүйгээс багийн шуудан үйлчилгээ тогтмолжиж чадахгүй байна. Аймгийн Засаг даргын 2010 оны а/20 дугаар захирамжаар орон нутгийн тээврийн үйлчилгээний чиглэл, жишиг тарифыг тогтоосон, одоогоор Сайншанд, Иххэт сумдад тээвэр зохицуулагч ажиллуулж эхлээд байгаа.	100
22	17.4. Малчин бүрийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлж, үйл ажиллагааг зохион байгуулах	Тус аймагт даатгалын үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо 2010 онд шалгалт хийж, холбогдох мэдээллийг аймгийн удирдлагуудад өгсөн. Дэлхийн банкны төсөл хэрэгжүүлэх нэгжээс тус аймагт “Малын индексжүүлсэн даатгал” төслийг хэрэгжүүлэх болсон. Тус төслийн зохицуулагч, менежерийн сонгон шалгаруулалтыг 2010 оны 10 дугаар сард явуулж, тэдгээр ажигнуудыг сонгож ажилд нь оруулаад байна. Төслийн зохицуулагч, менежерүүд сумдад ажиллах даатгалын төлөөлөгчдийг сонгон авахаар “Монгол даатгал”, “Бодь даатгал”, “Практикал даатгал”-ын салбар нэгжүүдтэй хамтарч, судалж байна.	90
23	18.2. Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах арга хэлбэрийг өөрчилж, “Ногоон ажлын байр” санаачлагыг дэмжих	“Ногоон ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд 8 удаагийн ажлыг зохион байгуулж, 155 иргэнийг хамруулан 14.5 сая төгрөг, эмзэг бүлгийн иргэдийг хөдөлмөрт хамруулах төсөлд 40 иргэнийг хамруулж, 462.0 мянган төгрөг, орон нутгийн чанартай 14 төрлийн ажилд 266 иргэнийг хамруулж 36.2 сая төгрөг, 13 удаа зохион байгуулсан цагийн ажилд 234 иргэнийг хамруулан 15.7 сая төгрөгийг зарцуулсан. Эдгээр ажлуудад эмзэг бүлгийн 113 иргэн хамрагдсан байна.	100

24	18.4. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн эцэг эх, гэр бүлийн гишүүдийг орлоготой болгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2010 онд хүүхдийн талаар авсан судалгаанаас харахад хөдөлмөр эрхэлж байгаа 61 хүүхэд байна. “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг утсгах” төслийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр 6 суманд хэрэгжүүлж байна. Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд дэмжлэг үзүүлэх “Scream” төслийг тус аймагт мөн хэрэгжүүлдэг. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, түүний гэр бүлд зориулсан сургалт, мэдээллийн үйлчилгээг тогтмол явуулж ирлээ.	100
25	18.8. Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн шинэчилсэн өөрчлөлтийн дагуу бүртгэл, мэдээллийг сайжруулах	Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн бүртгэл, мэдээллийг сайжруулах арга хэмжээ авч байна. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэгдсэн ажилгүйдчүүд 656 байгаа нь өмнөх оныхоос 124 хүнээр буюу 23,3 хувиар нэмэгдсэн, ажилгүйдлийн түвшин 3,4 байгаа нь улсын дунджаас 8,3 хувиар бага байна.	100
26	18.11 МСҮТ-д суралцагчдын тоог нэмэгдүүлэх, түргэвчилсэн сургалтаар мэргэжил олгох үйл ажиллагааг дэмжиж урамшуулах	Аймгийн МСҮТ 80 хүүхдийн дотуур байр, спорт заал, хурлын танхим, номын сан, лаборатори дадлагын газартай, говийн бүсийн мэргэжил арга зүйн төв, бизнесийн хөгжлийг дэмжих төвтэй болж өргөжсөнөөр суралцагчдын тоо жил тутам нэмэгдэж байна. 2010-2011 оны хичээлийн жилд 12 мэргэжлээр 913 суралцагч суралцаж, 36 багш ажиллаж байна. Говийн бүсийн уул уурхайн үйлдвэрлэл, түүний дэд бүтцэд ажиллах мэргэжилтэй ажилчин, ажилтнуудыг бэлтгэх хэрэгцээг үндэслэн тус төвд АНУ-ын мянганы хөгжлийн сорилтын сангийн 39,0 мянган ам.долларын хөрөнгөөр уул уурхайн чиглэлийн 3 анги шинээр нээж, 62 хүүхэд элсүүлж, сургалтын иж бүрэн техник хэрэгслээр хангалаа. Мөн “Оюу толгой” ХХК-ын зардлаар мэргэжилтэй ажилчин бэлтгэх сургалтанд 80 хүнийг сонгон, аймгийн МСҮТ-ийг түшиглүүлэн хичээллүүлэхээр шийдвэрлээд байна.	100
27	19.8. Эрүүл мэндийн үйлчилгээнд “Эрхийн бичиг”-ийн тогтолцоог нэвтрүүлж, иргэн бүрийг жилд 1 удаа эмнэлгийн иж бүрэн, нарийн мэргэжлийн цогц үзлэг, оношлогоонд хамруулах	Эрүүл мэндийн үйлчилгээнд “Эрхийн бичиг”-ийн тогтолцоог нэвтрүүлж эхлээгүй. Харин 2009, 2010 онуудад аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Явуулын амбулатори”-ийг 14 суманд ажиллуулж, иргэдийг үнэ төлбөргүй үзлэг, шинжилгээнд хамруулж, зохих шатлалын эмнэлгүүдэд эмчлэх, сувилуулах ажлыг хийж ирсэн. Солонгос улсын нарийн мэргэжлийн 50 гаруй эмч, мэргэжилтэн, сайн дурын ажилтан 2009 оны 7 дугаар сард Сайншанд суманд ажиллаж, 2400 хүнд үзлэг хийж, эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэн, 18 хүнд хагалгаа хийсэн байна. Мөн Япон улсын нарийн мэргэжлийн эмч нар тус аймагт 2009 оны 9 дүгээр сард ирж 0-15 насны хүүхдүүдэд үзлэг, оношлогоо хийж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлжээ.	90
28	19.10.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зайны оношлогооны цахим эмнэлгийн нэгдсэн сүлжээг байгуулах	Аймгийн нэгдсэн эмнэлэгт Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр “Эх, нярайн тусламжинд зайн оношлогооны дэмжлэг үзүүлэх” төсөл хэрэгжиж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр 100 хувь хангасан. Энэ төслийн зардлаар 2 их эмч Тайваньд, 1 их эмч Сингапурт мэргэжил дээшлүүлээ. Эх,нярайн зайн оношлогооны кабинет тайлант хугацаанд 3300 хүнд, зүрх судасны оношлогооны кабинет 465 хүнд үйлчилгээ үзүүлсэн. Зайн оношлогооны кабинетууд 13 өвчтөний мэдээллийг 3 дахь шатлалын эмнэлэг рүү дамжуулж, 3 хүнийг мэс заслын тусламжинд хамруулсан байна.	90
29	19.11. Монгол улсын нутаг дэвсгэрийн аль ч цэгт	Аймгийн түргэн тусламжийн албыг түшиглэн яаралтай тусламжийн тасгийг 2 ортой байгуулж, монитор, пульсоксиметр, хүчилтөрөгч өтгөрүүлэгч зэрэг нэн шаардлагатай	

	хүрэх “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ”-г бий болгох	багаж тоног төхөөрөмжийг суурилуулсан, 2010 онд 159 хүнд яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд Даланжаргалан, 2010 онд Эрдэнэ, Алтанширээ, Мандах, Хөвсгөл сумдын түргэн тусламжийн автомашиныг шинэчилж, аймгийн болон Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт 1-3 автомашин, “Тогтвортой амьжиргаа” төслийн хөрөнгөөр Сайхандулаан суманд автомашин олгосноор аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хугацааны эхний хагаст түргэн тусламжийн авто машины парк шинэчлэлт 55,2 хувьтай байна. Мөн улсын төсөв болон Тогтвортой амьжиргаа” төслийн хөрөнгөөр Улаанбадрах, Мандах, Дэлгэрэх сумдын багийн эмчид мотоцикль олгосон.	90
30	19.13. Малчин, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг нөхөн үржихүйн эм хэрэгслээр тогтвортой хангах	Хэвийн явцтай жирэмсэн эхийн хяналтыг Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн эмчийн хяналтанд шилжүүлж, төрөх эхчүүдийн 96,8 хувийг нэгдсэн эмнэлгүүдэд төрүүлэн, жирэмсний хяналт, жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэлүүдээс сэргийлэх нөхцлийг бүрдүүллээ. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт байвал зохих багаж тоног төхөөрөмжийн хангалт 80,0 хувьтай байна. 2010 онд нярайн сэхээн амьдруулах тасагт 0,6 сая, сум, өрхийн эмнэлгүүдэд эх, нярайн тусламжийн 2,1 сая төгрөгийн эм, хэрэгслийг “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” хөтөлбөрийн хөрөнгөөр олгосон. Аймгийн хэмжээнд эхийн амрах байр 12 ажиллаж, шаардлага хангасан үйлчилгээ үзүүлж байна. Тайлант хугацаанд 1213 эхийг хяналтанд авснаар эрт үеийн хяналт 82,0 хувьтай болжээ.	100
31	19.15. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх, хүүхдийн тасгийн тоног төхөөрөмжийг сайжруулах	Хэвийн явцтай жирэмсэн эхийн хяналтыг Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн эмчийн хяналтанд шилжүүлж, төрөх эхчүүдийн 96,8 хувийг нэгдсэн эмнэлгүүдэд төрүүлэн, жирэмсний хяналт, жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэлүүдээс сэргийлэх нөхцлийг бүрдүүллээ. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт байвал зохих багаж тоног төхөөрөмжийн хангалт 80,0 хувьтай байна. 2010 онд нярайн сэхээн амьдруулах тасагт 0,6 сая, сум, өрхийн эмнэлгүүдэд эх, нярайн тусламжийн 2,1 сая төгрөгийн эм, хэрэгслийг “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” хөтөлбөрийн хөрөнгөөр олгосон. Аймгийн хэмжээнд эхийн амрах байр 12 ажиллаж, шаардлага хангасан үйлчилгээ үзүүлж байна. Тайлант хугацаанд 1213 эхийг хяналтанд авснаар эрт үеийн хяналт 82,0 хувьтай болжээ.	100
32	19.19. Эрүүл мэндийн үйлчилгээнд “Урьдчилан сэргийлэх нь эмчлэхээс хялбар” зарчмыг баримталсан шинэ аргачлал нэвтрүүлэх, хүн амыг эрүүлжүүлэх төвийг байгуулахад дэмжлэг үзүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулсан, эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг 829 удаа хийж, даохардсан тоогоор 50,2 мянган хүнийг хамруулсан. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцыг 12 суманд шалгасан.	100
33	20.1. Баг бүрийг гэр цэцэрлэгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа □Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл□ төслийн 40,2 сая төгрөгийн хөрөнгөөр 6 суманд гэр цэцэрлэг, тавилга, тоног төхөөрөмжийн хамт нийлүүлсэн. □Тогтвортой амьжиргаа□ төслийн 7,9 сая төгрөгийн хөрөнгөөр Алтанширээ, Даланжаргалан сумдад гэр цэцэрлэг нийлүүлсэн. Өргөн суманд орон нутгийн төсвөөс 4,6 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэж гэр цэцэрлэг ажиллууллаа.	70
34	20.8. ЕБС-ийн сурагчдыг “Үдийн хоол” хөтөлбөрт хамруулах ажлыг эхлүүлэх	Аймгийн хэмжээнд 1-5 дугаар ангийн 5998 хүүхэд “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж байна. 2009 -2010 оны хичээлийн жилд ЕБС-д “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	

		аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь тавих хяналт сайжирсан байна. Аймгийн БСГ-аас 2010 оны 3 дугаар сард бүх сумын сургуулиудад хийсэн шалгалтаас ийм үнэлгээ өгчээ. “Өдрийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл болгож Боловсролын салбарын болон төслийн хөрөнгө оруулалтаар Айраг, Эрдэнэ, Сайншандын I, II дунд сургуульд тус бүрт нь 25,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гал тогооны цахилгаан тоног төхөөрөмж олгосныг зохих шаардлага хангасан байранд суурилуулж, ашиглаж байна.	90
35	20.24. Математик болон байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийг аймаг, дүүрэг бүрт I-ийг зайны сургалтынг ашиглан зохион байгуулж ажиллуулах	Математик болон байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай ангийг Сайншанд сумын I, II дунд сургууль, Замын-Үүд сумын сургуулиудад хичээллүүлж байна. Эдгээр сургуулиудад “Багш хөгжлийн төв” болон мэдээллийн технологийн төвүүд байгуулсан.	90
36	22.5. Соёл урлагийн байгууллагуудын материаллаг баазыг сайжруулж, алслагдсан бүс нутагт явуулын үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх	“Тогтвортой амьжиргаа” төслийн хөрөнгөөр Айраг, Мандах, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг сумдын соёлын төвүүдэд нийтдээ 65.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, их засвар, тохижилтын ажлыг хийсэн, улсын төсвийн хөрөнгөөр Даланжаргалан сумын соёлын төвийн засвар, тохижилтын ажлыг хийсэн. “Саран хөхөө” театрын барилгын өргөтгөл, шинэчлэлтийг РЭМУГС ХХК гүйцэтгэж, 2010 оны 6 дугаар сард ашиглалтанд хүлээлгэж өгсөн. Сайншанд суманд Ёс заншил, өв соёл, хүндэтгэлийн ордны барилгыг 2010 оны 7 дугаар сараас “Сондуулт Эг” ХХК улсын төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар эхэлсэн. Барилгын суурийн ажил дуусч, ханын өрөг угсралтын ажил хийгдэж байгаа.	90
37	28.2. Хууль тогтоомж зөрчих явдлыг хязгаарлаж, иргэдийн амь нас, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлын цар хүрээг өргөтгөх	14 суманд эрх зүйн мэдээлийн гар болон цахим сан ажиллаж байна. Сайншанд, Айраг, Замын-Үүд сумдад интернэтээр эрх зүйн мэдээллийг авч байна. Цаашид үүрэн телефоныг ашиглан эрх зүйн мэдээллийн сан www.Legalinfo.mn -ийг тогтмол хэрэглэх боломжтой болох юм. Аймгийн Засаг даргын Тамгын газарт байрладаг эрх зүйн туслалцааны төв нь гэрээгээр өмгөөлөгч ажилуулж, төлбөрийн чадваргүй иргэд, төрийн албан хаагчдад үнэ төлбөргүй зөвлөгөө, лавлагаа өгч гарын авлага материалаар хангаж байна. Мөн өмгөөлөгч нь төрийн алба, төрийн байгууллагатай холбогдолтой маргааныг шүүхээр шийдвэрлэхэд биечлэн оролцож, мэргэжлийн зөвлөгөө, лавлагаа өгч байна. ХЗҮТ-өөс өдөр тутам хэрэглэгддэг 89 хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө, анхааруулга, санамж зэрэг 3000 гаруй эрх зүйн гарын авлага материал ирүүлснийг сум, агентлагуудад хуваарилан олгосон байна.	90
38	28.4. Мэргэжлийн хяналтын үйл ажиллагаанд удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар Төрийн хяналт шалгалтын тухай болон салбарын бусад хууль тогтоомжийг удирдлага болгон хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах, чанартай бүтээгдэхүүн хэрэглэх, хөдөлмөрлөх эрхийг хангах, бизнес эрхлэгчдийн таатай орчинг бүрдүүлэх, төрийн өмчийн болон төсвийн байгууллагуудад санхүүгийн сахилгыг дээшлүүлэх үндсэн зорилгоо бүрэн хэрэгжүүлж ирсэн. 2009 оны үйл ажиллагааны үр дүнгээр 91,6 хувь /шаардлага бүрэн хангаж байгаа/ гэсэн үнэлгээгээр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас 3 дугаар байр эзэлсэн. 2010 онд төсвийн 376, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой 88, орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 115, хувийн хэвшлийн 2058,	100

		бусад 131, бүгд 2768 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Төсөвт нөхөн төлүүлэхээр 69,2 сая төгрөгийн төлбөр тогтоосны 54,7 хувийг, 20,8 сая төгрөгийн торгууль, шийтгэл оногдуулсны 80,7 хувийг тус тус барагдуулаад байна.	
39	28.7. Замын-Үүдийн хилийн боомтод олон улсын шаардлагад нийцсэн хорио цээрийн байгууламж барих ажлыг эхлүүлэх	Хэрэгжилтийн үнэлгээг орон нутгаас гаргах боломжгүй	-
40	29.4. Бүх шатны байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, гамшгийн эрсдлийг бууруулах сан байгуулах	Аймгийн Засаг даргын 2010 оны а/73 дугаар захирамжаар өгөгдсөн үүргийн дагуу аймгийн 10 алба, 14 сум, 44 баг, 60 аж ахуйн нэгжийн удирдлагууд гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулж, тухайн шатны Засаг даргаар батлуулан мөрдөж байна. Мөн аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн тодотгосон. “Томуугийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөө”, “Томуугийн цар тахлын үед хэрэгжүүлэх аарга хэмжээний төлөвлөгөө”-г шинээр боловсрууллаа. “Малын сэг, зэмийг устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 246 дугаар тогтоол, Улсын Онцгой Комиссын 2010 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 14 дүгээр хуралдааны шийдвэр, “Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 246 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээнд холбогдох төлөвлөгөөнд тодотгол хийж, үйл ажиллагааг зохион байгууллаа. Мал аж ахуйн үйлдвэрлэлд учрах эрсдлээс хамгаалах, хохирлыг барагдуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой малчдад туслах хандивын санг байгуулсан. Тус сангаас малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналтын цэг, хөдөлгөөнт эргүүл, ариутгал халдваргүйжүүлэлтийн цэг ажиллуулах, өвчилсөн малыг устгах зэрэг үйл ажиллагаанд 2010 онд 34,1 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан.	100
41	30.5. Замын-Үүд, Айраг сумдад аврах, гал унтраах анги шинээр байгуулах	Монгол улсын Засгийн газрын 2009 оны 322 дугаар тогтоолоор Замын-Үүд суманд аврах, гал унтраах 17 дугаар анги, Айраг суманд гал унтраах 23 дугаар ангийг 2010-2011 онд байгуулахаар шийдвэрлэсэн. Замын-Үүд сумын аврах, гал унтраах ангийн барилгын нийт төсөвт өртөг 882.0 сая төгрөг бөгөөд 2010 онд 270.0 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэгдэж, “Наранбулаг трейд” ХХК гүйцэтгэгчээр ажиллаж байна. Айраг сумын гал унтраах анги болон 8 айлын орон сууцны барилгын нийт төсөвт өртөг 936.0 сая төгрөг, үүнээс 2010 онд 350.0 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс хийсэн. Гүйцэтгэгч нь “Бүтээлч шинэ сонголт” ХХК болно.	90
42	33.2. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хянах цахим, нээлттэй системийг бий болгох	Аймгийн Засаг даргын 2009 оны 426 дугаар захирамжаар иргэдийн санал, хүсэлт, гомдол, мэдээллийг телефон утсаар хүлээж авах журмыг баталж, тэдгээр утсыг аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийг хүлээн авах байр, аймгийн „Нэг цонхны үйлчилгээ”,-ний төвд байрлуулсан юм. Аймгийн SBS телевиз, FM 107.5 радиог ашиглан аймгийн удирдлагууд иргэдтэй шууд ярилцлага зохион байгуулж, мэдээлэл хийж, иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгч ирлээ. Иргэдийн санал, хүсэлт, гомдол, мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын “Иргэдийг хүлээн авах байр”-ны 23913 тоот утас, аймгийн “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийн 23597 тоот утсаар ажлын цагт авч байна. 2010 оны байдлаар эдгээр утсаар нийт 21 иргэнээс санал, хүсэлт ирснийг хүлээн авч	100

		шийдвэрлэсэн байна. “Нээлттэй утас”-ыг 5 сумын Засаг даргын Тамгын газар, 4 агентлагт ажиллуулж байна.	
43	34.14. Малын хулгайн гэмт хэргээс сэргийлэх санд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хэсгийн төлөөлөгчдийн ажлын нөхцөл, унаа, техник хэрэгслээр хангах арга хэмжээ авах	Аймгийн Засаг дарга аймгийн Цагдаагийн газрын Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн автомашины засварт 980.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Энэ төрлийн гэмт хэргийн мэдээ, цаашид авах арга хэмжээний талаар сумдын Засаг дарга, төрийн албан хаагчдын сургалт, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөлгөөн, багийн өдөрлөг, малчдын бүлэг, нөхөрлөлийн хурал цуглаан зэрэг арга хэмжээнд 10 гаруй удаа оролцож мэдээлэл өгсөн. Аймгийн ИТХ, ГХУССЗ, хуулийн байгууллагууд хамтарч Сайншанд, Айраг, Алтанширээ, Иххэт, Дэлгэрэх, Даланжаргалан сумдад мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх талаар зохиож байгаа ажилд үзлэг шалгалт хийж, хууль, хяналтын байгууллагуудын “нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулсан. Зохион байгуулсан ажлын үр дүнд малын хулгайн гэмт хэргийн илрүүлэлт 57,1 хувь болж, энэ төрлийн гэмт хэргийн тоо өмнөх оныхоос 45,5 хувиар, холбогдогсдын тоо 48,9 хувиар тус тус буурчээ.	90
44	34.16. Төрийн байгууллага, албан тушаалтны хуульд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээ авч байх	Аймгийн ЗДТГ-ын даргын болон зарим агентлаг, 14 сумын Засаг даргын батлан гаргасан 1350 захирамж, мөн Биеийн тамир спортын газар, Нэгдсэн эмнэлгийн дарга нарын гаргасан 162 тушаалыг хянаж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан. Замын-Үүд сумын ИТХ, Засаг даргаас гаргасан, төлбөр хураамжийн хэмжээ тогтоосон 3 шийдвэрийн хуулийн үндэслэлийг тодруулахаар ЗТАЖЯ, Гаалийн Ерөнхий газарт хүргүүлээд байна.	90
45	34.19. Цагдаагийн албан хаагчийн дундаж ачааллыг судалж, орон тоог бодит ачаалалд нийцүүлэх арга хэмжээ авах	Хэрэгжилтийн үнэлгээг орон нутгаас гаргах боломжгүй	-
46	35.4. Нийгмийн хэв журам хамгаалах чиглэлээр ажилладаг цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээ авах	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах хүрээнд Цагдаагийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор аймгийн Цагдаагийн газарт согтуурлын зэрэг тогтоох 2 ширхэг багаж, төхөөрөмж худалдан авахад 1,0 сая, автомашины засварт 0,98 сая, Мандах, Сайхандулаан сумдын хэсгийн төлөөлөгч тус бүрт 2,7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж унаатай болгосон, аймгийн төвд хэсгийн байцаагч, цагдаагийн тасагт зориулалтын тоноглол бүхий 2 мотоцикль олгосон.	90
Гүйцэтгэлийн дундаж хувь			89,5
Үнэлгээний оноо			4,47

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР